



МОНГОЛ УЛСЫН  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ТУШААЛ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Матад-ХХ талбайн нөөц бүртгэх тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Газрын тосны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн Матад сумын нутаг, газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээт Матад-ХХ талбайд орших газрын тосны “Цэн тогоруу” ордын газрын тосны нөөцийг “баталгаат (1P)” зэрэглэлээр 1 151 194.0 тонн (8.68 сая баррель)-оор, үүнээс ашиглалтын баталгаат нөөцийг 137 931.0 тонн (1,04 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай (2P)” зэрэглэлээр 3 051 724.0 тонн (23.01 сая баррель)-оор, “баталгаат+магадлалтай+боломжтой (3P)” зэрэглэлээр 5 385 942.0 тонн (40.61 сая баррель)-оор хүлээн авсугай.

2. Дээрх хүлээн авсан газрын тосны ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Үндэсний геологийн алба (О.Чулуун)-д зөвшөөрсүгэй.

3. Дорнод аймгийн Матад сумын нутаг дахь Матад-ХХ талбайд орших газрын тосны “Цэн тогоруу” ордын баялгийн үнэлгээ, нөөцийн тооцооны тайланг бичвэр дискийн хамт Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны дүгнэлт, түүний дагуу гаргасан энэхүү тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан Үндэсний геологийн албаны Геологийн баримтын төв архивт хүлээлгэн өгөхийг “Петро матад” ХХК (Майк Бак)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдааны 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн СТР-02-01 дүгээр дүгнэлтийн 10 дугаар заалтыг цаашдын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг “Петро матад” ХХК (Майк Бак)-д даалгасугай.

5. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын тосны бодлогын газар /Б.Анхбаяр/-т, Ашигт малтмал, газрын тосны газар /Х.Хэрлэн/-т тус тус даалгасугай.

